

**ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД БА ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧДАД
ЗОРИУЛСАН (2023-2024 ОНЫ ТОМЬЁО)
КОРОНАВИРУС 2019 (КОВИД-19) ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ЗОРИЛГООР ЯАРАЛТАЙ ХЭРЭГЛЭХ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ МОДЕРНА КОВИД-
19 ВАКЦИНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС
6 САРААС 11 ХҮРТЭЛХ НАСНЫХАНД ЗОРИУЛСАН**

Таны хүүхдэд SARS-CoV-2 коронавирусаар халдварладаг коронавирус 2019 (КОВИД-19) өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ¹Модерна КОВИД-19 вакциныг (2023-2024 оны томьёо) санал болгож байна. Энэхүү мэдээллийн хуудас нь танд өнөөгийн КОВИД-19 цар тахлын улмаас танд хүүхэд хийлгэж болзошгүй, цаашид Модерна КОВИД-19 вакцин гэх Модерна КОВИД-19 вакцины (2023-2024 оны томьёо) эрсдэл, давуу талуудын талаар ойлгоход туслах мэдээлэл агуулдаг. Хэрвээ танд асуулт үүсвэл та хүүхдийнхээ вакцин нийлүүлэгчтэйгээ ярина уу.

Энэхүү Мэдээллийн Хуудас цаашид шинэчлэгдэх болно. Хамгийн сүүлийн Мэдээллийн Хуудсыг www.modernatx.com/covid19vaccine-eua вебсайтаас үзнэ үү.

АНУ-ын Хүнс, Эмийн Захиргаанаас (ХЭЗ) Модерна КОВИД-19 вакциныг КОВИД-19 цар тахлын үед хэрэглэх боломжтой болгохын тулд Яаралтай хэрэглэх зөвшөөрөл (ЯХЗ) олгосон (энэ бичиг баримтын төгсгөлд буй ЯХЗ-ийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг "**Яаралтай хэрэглэх зөвшөөрөл гэж юу вэ?**" хэсгээс үзнэ үү). Модерна КОВИД-19 вакцин нь ХЭЗ-аас Америкийн Нэгдсэн Улсад 6 сараас 11 насны хүүхдүүдэд хэрэглэхээр зөвшөөрөгдсөн вакцин биш юм. Модерна КОВИД-19 вакцины тухай мэдээллийг энэхүү Мэдээллийн хуудаснаас уншина уу.

КОВИД-19 ГЭЖ ЮУ ВЭ?

КОВИД-19 өвчин нь SARS-CoV-2 хэмээх коронавирусаас үүсдэг. Та вирус тээж буй хүнтэй ойртож харьцсанаар КОВИД-19-ийн халдвар авч болзошгүй.

Энэ бол ихэвчлэн бусад эрхтэнүүдэд нөлөөлж болзошгүй амьсгалын замын өвчин юм. КОВИД-19-ээр өвдсөн хүмүүст өргөн хүрээний шинж тэмдэгүүд илэрдэг ба дундаж зэргээс маш хүнд шинж тэмдэг илэрч, үхэлд ч хүргэж болдог. Вирусын халдвар авснаас хойш 2-оос 14 хоногийн дараа шинж тэмдэг илэрч болно. Шинж тэмдгүүд доорхийг нэгтгэнэ: халуурах; бие арзайх; ханиах; амьсгалахад хүндрэлтэй болох; ядрах; булчин ба бие өвдөх; толгой өвдөх; үнэртэх болон амтлах чадвараа алдах; хоолой хөндүүрлэх; хамар битүүрэх; нус гоожих; дотор муухайрах; бөөлжих; гүйлгэх.

МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИН ГЭЖ ЮУ ВЭ?

Модерна КОВИД-19 вакцин нь КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх зорилгоор 6 сараас 11 насны хүүхдүүдэд хэрэглэх вакцин юм. ХЭЗ нь ЯХЗ-ийн дагуу Модерна КОВИД-19 вакциныг яаралтай хэрэглэх зөвшөөрөл олгосон.

Модерна КОВИД-19 вакцин нь хүн бүрийг хамгаалж чадахгүй байж магадгүй.

¹ Модерна КОВИД-19 вакцин (2023-2024 оны томьёо) нь Омикрон ХВВ.1.5 SARS-CoV-2-ийн баяжуулалтын уургийг кодогдог.

ТАНЫ ХҮҮХЭД МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИНЫГ ХИЙЛГЭХЭЭС ӨМНӨ ТА ВАКЦИН НИЙЛҮҮЛЭГЧДЭЭ ЮУГ МЭДЭЭЛЭХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

Та вакцин нийлүүлэгчдээ өөрийнхөө хүүхдийн эрүүл мэндийн байдлын тухай, доорхыг оруулан мэдэгдэнэ:

- ямар нэгэн харшилтай
- өмнө нь миокардит (зүрхний булчингийн үрэвсэл) эсвэл перикардит (зүрхний гаднах бүрхүүлийн үрэвсэл) зэрэг өвчнөөр өвдөж байсан эсэх
- халуурч байгаа
- цус алдалтын эмгэгтэй эсвэл цус шингэлэгч эм хэрэглэдэг
- дархлаа суларсан эсвэл таны дархлааны тогтолцоог өөрчлөх эм хэрэглэдэг
- жирэмсэн эсэх
- хөхүүл
- өөр ямар нэгэн КОВИД-19-ийн вакцин хийлгэсэн
- тарилгаас шалтгаалан ухаан алдаж байсан

ВАКЦИНЫГ ЯАЖ ХИЙДЭГ ВЭ?

Модерна КОВИД-19 вакциныг тариа байдлаар булчинд тарьж хэрэглэнэ.

6 сараас 4 насныханд:

- **Вакцин хийлгээгүй хүмүүст:** Модерна КОВИД-19 вакцины хоёр тун хийнэ. Хоёр дахь тунг эхний тунгаас 1 сарын дараа хийнэ.
- **Модерна КОВИД-19 вакцин (Анхны моновалент)²эсвэл Модерна КОВИД-19, Бивалент вакцины нэг тун хийлгэсэн хүмүүст:** ³ Модерна КОВИД-19 вакцин (Анхны моновалент) эсвэл Модерна КОВИД-19, Бивалент вакцин хийлгэснээс хойш 1 сарын дараа Модерна КОВИД-19, Бивалент вакцины нэг тун хийнэ.
- **Модерна КОВИД-19 вакцин (Анхны моновалент) эсвэл Модерна КОВИД-19, Бивалент вакцины хоёр эсвэл түүнээс дээш тун хийлгэсэн хүмүүст:** Модерна КОВИД-19 вакцин (Анхны моновалент) эсвэл Модерна КОВИД-19, Бивалент вакцины өмнөх сүүлийн тунг хийлгэснээс хойш багадаа 2 сарын дараа Модерна КОВИД-19 вакцины нэг тун хийнэ.

5 наснаас 11 насны хүүхдүүдэд:

- **Вакцин хийлгээгүй хүүхдүүдэд:** Модерна КОВИД-19 вакцины нэг тун хийнэ.
- **Моновалент КОВИД-19 вакцин⁴ эсвэл бивалент КОВИД-19 вакцины нэг эсвэл хоёр тун хийлгэсэн хүмүүст:** ⁵Модерна КОВИД-19 вакцины нэг тунг моновалент КОВИД-19 вакцин эсвэл бивалент КОВИД-19 вакцины өмнөх сүүлийн тун хийлгэснээс хойш багадаа 2 сарын дараа хийнэ.

² Анхны моновалент Модерна КОВИД-19 вакцин нь АНУ-д хэрэглэхийг зөвшөөрөөгүй зөвхөн анхны SARS-CoV-2 баяжуулалтын уургийг кодолодог.

³ Модерна КОВИД-19, Бивалент вакцин нь АНУ-д ашиглах зөвшөөрөлгүй зөвхөн анхны SARS-CoV-2 болон Омикрон BA.4/BA.5 SARS-CoV-2 баяжуулалтын уургийг кодолодог.

⁴ Моновалент гэдэг нь зөвхөн анхны SARS-CoV-2-ын баяжуулалтын уургийг кодолодог КОВИД-19 вакциныг хэлнэ.

⁵ Бивалент гэдэг нь зөвхөн анхны SARS-CoV-2 болон Омикрон BA.4/BA.5 SARS-CoV-2 баяжуулалтын уургийг кодолодог КОВИД-19 вакциныг хэлнэ.

6 сараас 11 нас хүртэлх дархлаа сүлтай хүмүүс:

Модерна КОВИД-19 вакцины нэмэлт тунгуудыг хийж болно. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл хүүхдийнхээ эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ ярилцана уу.

МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИНЫГ ХЭН ХИЙЛГЭЖБОЛОХГҮЙ ВЭ?

Хэрэв таны хүүхэд дараах асуудалтай бол Модерна КОВИД-19 вакцин хийлгэж болохгүй:

- Модерна КОВИД-19 вакцины өмнөх тунг хийлгэсний дараа маш хүчтэй харшлын урвал илэрсэн.
- эдгээр вакцины аль нэг найрлагад хүчтэй харшлын урвал үзүүлсэн.

ЭНЭ ВАКЦИНЫ НАЙРЛАГАД ЯМАР БОДИСУУД ОРСОН БЭ?

Модерна КОВИД-19 вакцин доорх найрлагатай: мессенжер рибонуклеины хүчил (mRNA), липидүүд (SM-102, полиэтилен гликол [PEG] 2000 димиристойл глицерол [DMG], холестерин, 1,2-дистеароил-сн-глицеро-3-фосфохолин [DSPC]), трометамин, трометамин гидрохлорид, цууны хүчил, натрийн ацетат тригидрат, сахароз.

ЭНЭ ВАКЦИН ӨМНӨ НЬ ХЭРЭГЛЭГДЭЖ БАЙСАН УУ?

6 сар ба түүнээс дээш насны олон сая хүн ЯХЗ-ийн дагуу Модерна КОВИД-19 вакциныг хийлгэсэн. Өөр клиник судалгаанаас үзэхэд 6 сараас 5 насны 5,000 орчим, 6 наснаас 11 насны 4,000, 12 болон түүнээс дээш насны 30,00 хүн Модерна КОВИД-19 вакцины (анхны моновалент) багадаа 1 тунг хийлгэсэн байна.

Модерна КОВИД-19 вакциныг Модерна КОВИД-19 вакцин (анхны моновалент) болон Модерна КОВИД-19, Бивалент вакциныг адил аргаар хийдэг боловч SARS-CoV-2 Омикрон хувилбарын ХВВ.1.5 баяжуулалтын уургийг кодогдог (Омикрон ХВВ.1.5).

МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИНЫ АШИГ ТУС ЮУ ВЭ?

ХЭЗ нь Модерна КОВИД-19 вакциныг КОВИД-19-өөс сэргийлэх зорилгоор хэрэглэх зөвшөөрөл олгосон. КОВИД-19-ээс хамгаалах чадвар үргэлжлэх хугацаа тодорхой бус байна.

МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИН ЯМАР ЭРСДЭЛТЭЙ ВЭ?

Вакцин нь харшлын ноцтой урвал өгөх боломжтой. Хүнд хэлбэрийн харшлын хүнд урвал нь вакцины тунг хийлгэсний дараа хэдэн минутаас нэг цагийн дотор илэрнэ. Энэ шалтгаанаар вакцин нийлүүлэгч таны хүүхдээс вакцин хийлгэсний дараа түүний биеийн байдлыг хянахаар тус байранд хэсэг хугацаанд байхыг асууж болно. Хүнд хэлбэрийн харшлын урвалын шинж тэмдэг:

- Амьсгалахад хүндрэлтэй болох
- Нүүр, хоолой хавагнах
- Зүрх хурдан цохилох
- Биеийн бүх хэсэгт тууралт гарах
- Толгой эргэх ба сульдах

mRNA Модерна КОВИД-19 вакцин хийлгэсэн зарим хүмүүс миокардит (зүрхний булчингийн үрэвсэл) эсвэл перикардитаар (зүрхний гаднах салст бүрхүүлийн үрэвсэл) өвдсөн. Модерна КОВИД-19 вакцины дараах миокардит, перикардит нь 18-24 насны насанд хүрсэн залуу эрэгтэйчүүдэд ихэвчлэн тохиолддог. Энэ хүмүүсийн ихэнхэд нь вакцин хийлгэснээс хойш хэд хоногийн дотор шинж тэмдэг илэрч эхэлсэн. Энэ тохиолдол үүсэх магадлал маш бага. Хэрэв таны хүүхдэд вакцин хийлгэсний дараа, ялангуяа вакцины нэг тунг хийлгэснээс хойш 2 долоо хоногийн дотор дараах шинж тэмдгүүдийн аль нэг нь илэрвэл та яаралтай эмнэлгийн тусламж авах хэрэгтэй:

- Цээжээр өвдөх
- Амьсгал давчдах эсвэл амьсгалахад хэцүү болох
- Зүрх хурдан, жигд бус, дэлсэх мэдрэмж төрөх

Ялангуяа таны хүүхдэд илэрч болзошгүй нэмэлт шинж тэмдгүүд:

- Ухаан алдах
- Хэвийн бус байх, байнга цухалдах
- Хоолны дуршил хэвийн бус болох, муудах
- Хэвийн бус, байнга ядрах эсвэл эрч хүчгүй болох
- Байнга бөөлжих
- Хэвлийгээр байнга өвдөх
- Хэвийн бус, байнга даарах, арьс цонхийх

Модерна КОВИД-19 вакцины клиник судалгааны үед дараах сөрөг нөлөө бүртгэгдсэн:

- Тариа хийсэн хэсгийн урвалууд: тариа хийлгэсэн гарын тунгалгийн булчирхай өвдөх, хөндүүрлэх, хавдах эсвэл цавь хавдах (хатуурах), улайх
- Ерөнхий гаж нөлөөнүүд: ядрах, толгой өвдөх, булчин өвдөх, үе мөч өвдөх, жихүүдэс хүрэх, дотор муухайрах, бөөлжих, халуурах, цочромтгой болох/уйлах, нойрмоглох, хоолны дуршил буурах

Вакцин хэрэглэх зөвшөөрөл авсны дараа доорх сөрөг нөлөө мэдэгдсэн:

- Хүнд хэлбэрийн харшлын урвал
- Чонон хөрвөс (загатнах тууралт/гүвдрүү)
- Миокардит (зүрхний булчингийн үрэвсэл)
- Перикардит (зүрхний гадна талын салст бүрхэвчийн үрэвсэл)
- Вакцин хийлгэсэнтэй холбоотойгоор ухаан алдах

Эдгээр нь бүх боломжит гаж нөлөө биш байж магадгүй юм. Ноцтой ба гэнэтийн сөрөг нөлөө үүсэж болзошгүй. Боломжит сөрөг нөлөөг судалж байгаа хэвээр байна.

СӨРӨГ НӨЛӨӨ ҮҮССЭН ТОХИОЛДОЛД БИ ЮУ ХИЙХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Хэрвээ таны хүүхдэд хүнд хэлбэрийн харшлын урвал илэрвэл 9-1-1 утас руу залгах эсвэл хамгийн ойрын эмнэлэгт хандана уу.

Хэрэв таны хүүхдийн сөрөг нөлөө арилахгүй хэвээр байгаа бол вакцин хийлгэсэн байгууллага эсвэл эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ холбогдоно уу.

Вакцины гадны нөлөөг FDA/CDC Вакцины Сөрөг Нөлөө Мэдээллэх Тогтолцоонд (VAERS) мэдээллэнэ үү. ВСНМС-ийн 1-800-822-7967 үнэгүй утасны дугаар эсвэл <https://vaers.hhs.gov/reportevent.html> вебсайтад онлайн горимд мэдээллэнэ үү. Тайлангийн маягтын 18-р хэсгийн эхний мөрөнд "Модерна КОВИД-19 вакцины (2023-2024 оны томьёо) ЯХЗ" гэж оруулна уу.

Түүнчлэн та сөрөг нөлөөний талаар 1-866-MODERNA (1-866-663- 3762) утсаар ModernaTX, Inc-д мэдээлж болно.

ХЭРЭВ БИ ХҮҮХДЭДЭЭ МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИН ХИЙЛГЭХГҮЙ ГЭЖ ШИЙДСЭН БОЛ ЯАХ ВЭ?

ЯХЗ-ийн дагуу энэ вакцинд хамрагдах эсвэл татгалзах сонголт хийх боломжтой. Хэрэв та хүүхдэдээ энэ вакциныг хийлгэхгүй гэж шийдсэн бол энэ нь стандарт эмнэлгийн тусламж авахад нөлөө үзүүлэхгүй.

МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИНААС ГАДНА КОВИД-19-ӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ӨӨР ВАКЦИН БАЙДАГ УУ?

SARS-CoV-2 Омикрон хувилбарын ХВВ.1.5 (Омикрон ХВВ.1.5) баяжуулалтын уургийг кодлодог вакцин зэрэг КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх бусад вакцинуудыг ЯХЗ-ийн хүрээнд хийлгэх боломжтой.

МИНИЙ ХҮҮХЭД МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИНЫГ БУСАД ВАКЦИНТАЙ ЗЭРЭГ ХИЙЛГЭЖ БОЛОХ УУ?

АНУ-ын ХЭЧХГ-т Модерна КОВИД-19 вакциныг бусад вакцинтай нэгэн зэрэг хэрэглэх талаарх мэдээлэл хараахан ирээгүй байна. Хэрэв та хүүхдэдээ Модерна КОВИД-19 вакциныг бусад вакцинуудтай хамт хийлгэх хэрэгтэй гэж үзэж байвал эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ ярилцана уу.

ХЭРЭВ МИНИЙ ХҮҮХЭД ДАРХЛАА СУЛТАЙ БОЛ ЯАХ ВЭ?

Дархлаа султай 6 сараас 11 настай хүүхдүүдэд Модерна COVID-19 вакцины нэмэлт тунг хийлгэж болно (дээрх **ВАКЦИНЫГ ХЭРХЭН ХИЙЛГЭХ ВЭ?** хэсгийг үзнэ үү).

Вакцинжуулалт нь дархлаа султай хүмүүст КОВИД-19-ийн бүрэн дархлаа тогтоохгүй байж болзошгүй тул та хүүхдээ КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэхийн тулд бодит арга хэмжээг үргэлжлүүлэх хэрэгтэй. Таны хүүхдийн ойр дотны хүмүүс зохих ёсоор вакцинжуулалтад хамрагдах хэрэгтэй.

ЖИРЭМСЭН ЭСВЭЛ ХӨХҮҮЛ БОЛ ЯАХ ВЭ?

Хэрэв таны хүүхэд жирэмсэн эсвэл хөхүүл бол эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ сонголтынхоо тухай ярилцана уу.

ВАКЦИН МИНИЙ ХҮҮХДЭД КОВИД-19 ХАЛДААХ УУ?


Үгүй. Энэ вакцин нь SARS-CoV-2 агуулдаггүй бөгөөд таны хүүхдэд КОВИД-19 халдаахгүй.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Хэрэв танд асууж лавлах зүйл байвал вебсайтад зочлох эсвэл доорх утсаар холбогдоно

уу. Хамгийн сүүлийн Мэдээллийн хуудаст нэвтрэхийн тулд доор өгөгдсөн QR кодыг

сканердана уу.

Модерна КОВИД-19 вакцины вебсайт	Утасны дугаар
www.modernatx.com/covid19vaccine-eua	1-866-MODERNA (1-866-663-3762)
	

БИ ХЭРХЭН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ АВАХ ВЭ?

- Вакцин хийлгэсэн байгууллагаас лавлаж асууна уу
- ХӨХУСТ-д вебсайтад <https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/index.html> холбоосоор нэвтэрнэ үү
- АНУ-ын ХЭЗ-ны вебсайтад <https://www.fda.gov/emergency-preparedness-and-response/mcm-legal-regulatory-and-policy-framework/emergency-use-authorization> холбоосоор нэвтэрнэ үү
- Муж эсвэл орон нутгийнхаа нийгмийн эрүүл мэндийн хэлтэстэй холбогдоно уу

ВАКЦИНЖУУЛАЛТЫН МЭДЭЭЛЭЛ ХААНА ХАДГАЛАГДАХ ВЭ?

Вакцин нийлүүлэгч нь таны хүүхдийн вакцинжуулалтын мэдээллийг танай муж/орон нутгийн харъяа Дархлаажуулалтын Мэдээллийн Тогтолцоо (IIS) эсвэл бусад тусгай тогтолцоонд оруулна. ДМС-ийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг: <https://www.cdc.gov/vaccines/programs/iis/about.html> холбоосоор нэвтэрч авна уу.

ХОХИРЛЫН НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХӨТӨЛБӨР ГЭЖ ЮУ ВЭ?

Хохирлын нөхөн төлбөрийн хөтөлбөр (CICP) нь тодорхой эм, вакцин, түүний дотор энэ вакцинаас болж ноцтой хохирсон хүмүүсийн эмчилгээний зардал, бусад тодорхой зардлуудыг нөхөн төлөхөд туслах холбооны хөтөлбөр юм. Ерөнхийдөө вакцин хийлгэснээс нэг (1) жилийн дотор CICP-т өргөдөл гаргах ёстой. Энэхүү хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.hrsa.gov/cicp/ вебсайт эсвэл 1-855-266-2427 утсаар холбогдоно уу.

ЯАРАЛТАЙ ХЭРЭГЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ГЭЖ ЮУ ВЭ (EUA)?

ХЭЗ нь Модерна КОВИД-19 вакциныг ЯХЗ гэж нэрлэгддэг яаралтай хэрэглэх механизмын дагуу ашиглах боломжтой болгосон. EUA нь Эрүүл Мэндийн Алба ба Хүний Үйлчилгээ (HHS)-ээс дэмжигддэг ба КОВИД-19 цар тахлын үед биологийн ба эмийн бүтээгдэхүүнүүдийг яаралтай хэрэглэх баталгааг гаргадаг. Яаралтай хэрэглэх зөвшөөрөл авсан бүтээгдэхүүн нь FDA-аас зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүнтэй адил төрлийн FDA-н хяналтад хамрагдаагүй.

АНУ-ын ХЭЧХГ нь өөр ямар нэгэн адил төстэй, батлагдсан, боломжит хувилбар байхгүй гэсэн тодорхой шалгуурыг хангасан тохиолдолд ЯХЗ олгоно. Мөн түүнчлэн АНУ-ын ХЭЧХГ-ын шийдвэр уг бүтээгдэхүүн КОВИД-19 цар тахлын үеэр КОВИД-19-өөс сэргийлэхэд үр дүнтэй, мөн тухайн бүтээгдэхүүний мэдэгдэж байгаа болон боломжит үр дүн нь мэдэгдэж байгаа болон болзошгүй эрсдэлээс илүү их нөлөөтэй гэдгийг шинжлэх ухааны бүх нотолгоонд үндэслэсэн байна. Бүтээгдэхүүнийг ЯХЗ-ийн дагуу КОВИД-19 цар тахлын үед ашиглахын тулд эдгээр бүх шалгуурыг хангасан байх ёстой.

ЯХЗ нь бүтээгдэхүүнийг цуцлах эсвэл хүчингүй болгохоос бусад тохиолдолд (үүний дараа бүтээгдэхүүнийг цаашид ашиглахгүй) яаралтай хэрэглэхийг зөвшөөрсөн КОВИД-19-ийн ЯХЗ-ийн мэдэгдлийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

Moderna US, Inc.
Princeton, NJ 08540

©2023 ModernaTX, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Патент(ууд): www.modernatx.com/patents
Хянасан: 2023/09/11



Энэхүү Мэдээллийн Хуудсыг вакцинд хамарсан хүмүүсийн эрүүл мэндийн цахим бүртгэл/дархлаажуулалтын мэдээллийн тогтолцоонд оруулсныг батлахаар скан хийж үзнэ үү.

ББГДТ: 0886983000615